АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Архангай аймгийн Эрдэнэбулган сумын Ар мөнгөн чагнуур ЗГБХН -ийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: АРА-2024/221/-НА-СТА-ТШ3**

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.open.audit.mn<br>Архангай аймаг<br>2023 он | Дарга,Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа<br>Утас:7033-3141<br>Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn<br>Аудитын менежер Д.Нэргүйбаатар<br>Утас: 7033-2860<br>Цахим хаяг: Nerguibaatard@audit.gov.mn<br>Гэрээгээр аудит гүйцэтгэсэн:<br>Бизкон аудит ХХК Архангай аймаг дахь салбар<br>Ахлах аудитор Ч.Анхбаяр<br>Утас: 8511-6555<br>Цахим хаяг: ankha964@gmail.com |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**Агуулга**


1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ ........ 3
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ ........ 5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ........ 5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ........ 6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан ........ 7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ........ 8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ........ 8
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА ........ 9
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа ........ 9
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин ........ 9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ........ 10
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд ........ 10
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв ........ 11
3.5.1 Төсвийн төлөвлөлт ........ 11
3.5.2 Төсвийн гүйцэтгэл ........ 11
3.5.3 Нэмэлт төсөв ........ 11
3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн ........ 11
3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл ........ 11
4.1 Ерөнхий зүйл ........ 12
4.2 Материаллаг байдал ........ 12
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт ........ 12
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт ........ 13
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ........ 13
4.5.1 Завсрын аудитын талаар ........ 13
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн ........ 13
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал ........ 13
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ ........ 14
5.1 Төлбөрийн акт ........ 14
**5.2** Албан шаардлага ........ **Error! Bookmark not defined.**
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ ........ 14

## Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |
| БГАҮТХ | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж |
| ЭМЯ | Эрүүл мэндийн яам |
| ЭМГ | Эрүүл мэндийн газар |
| ЭМДС | Эрүүл мэндийн даатгалын сан |
| ЭМТ | Эрүүл мэндийн төв |

## 1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АРХАНГАЙ АЙМАГ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
Нутгийн захиргааны ордон, А корпус, 2 дугаар баг,
Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65139,
Утас/Факс: (976) 7033 3141,
Цахим шуудан: arkhangai@audit.gov.mn

2024.02.25 № 138

танай ____________-ны №____________-т

АРХАНГАЙ АЙМГИЙН АР МӨНГӨН ЧАГНУУР ЗГБХН-ИЙН ДАРГА Б.ЦЭНГЭЛМАА ТАНАА

### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Архангай аймгийн Эрдэнэбулган сумын Ар мөнгөн чагнуур ЗГБХН-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.
Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Ар мөнгөн чагнуур ЗГБХН-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно. Үүнд:

2023 оны санхүүгийн тайлангаар 12,940.8 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байхад 16,230.9 мянган төгрөгийн 13 дахь сарын цалин олгосон байна.
Дээрх зөрчил Төсвийн тухай хуулийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Байгууллагын дотоод журмын 1.9.12 дахь заалт "Байгууллага санхүүгийн үр ашигтай ажилласан тохиолдолд 13 дахь сарын цалинг нийгмийн даатгал, ХХОАТ-ыг суутгаж олгож болно" гэсэн заалтыг зөрчсөн, аудитын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### Асуудлыг онцолсон хэсэг

Ар мөнгөн чагнуур ЗГБХН нь тайлант онд ЭМЯ-аас хандив тусламжаар 40,977.8 мянган төгрөгийн бараа материал, 20,211.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авсныг санхүүгийн тайланд тусгасан байна.

### Аудитын гол асуудал

Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай" Засгийн газрын 2023 оны 241 дүгээр тогтоолтой уялдуулан Ар мөнгөн чагнуур ЗГБХН-ийн 2023 оны 11 сарын 1-ний өдрийн бүх ажилчдын хурлын шийдвэрийг үндэслэн Ар мөнгөн чагнуур ЗГБХН-ийн даргын 11 сарын 1-ны өдрийн Б/44 дүгээр тушаалаар бүх ажилчдын цалинг нэмэгдүүлсэн байна. Үүнтэй

холбоотойгоор цалин хөлс, нэмэгдэл урамшууллын зардал өмнөх оноос 35.0 хувиар өссөн байна.

**Бусад асуудлын хэсэг**

Тус байгууллага нь Аймгийн засаг дарга, ЭМГ-ийн даргатай гуравласан гэрээ байгуулж, 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 3 үндсэн зорилтын хүрээнд 22 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг Аймгийн Засаг даргаас 92.3 хувьтай үнэлсэн байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Т.БАЙГАЛМАА

# 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

*2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* / төгрөгөөр /

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 201,760,333.76 | 87,597,396.21 |
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | 299,997.91 | 6,894,868.46 |
| 312 | Банканд байгаа бэлэн мөнгө | 299,997.91 | 6,894,868.46 |
| 3121 | Төгрөг | 299,997.91 | 6,894,868.46 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 299,997.91 | 6,894,868.46 |
| 33 | АВЛАГА | - | 13,184,408.01 |
| 33200 | Төлбөртэй үйлчилгээний авлага | - | 13,184,408.01 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 201,460,335.85 | 67,518,119.74 |
| 351 | Түүхий эд материал | 55,602,305.85 | 13,612,469.74 |
| 35130 | Эм боох материал | 55,602,305.85 | 13,612,469.74 |
| 354 | Хангамжийн материал | 145,858,030.00 | 53,905,650.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 4,290,800.00 | 1,483,920.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 136,710,240.00 | 46,080,740.00 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 1,716,000.00 | 1,430,000.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | | 780,000.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 3,140,990.00 | 4,130,990.00 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 56,204,574.03 | 157,426,693.82 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 56,204,574.03 | 157,426,693.82 |
| 392 | Биет хөрөнгө | 36,744,574.03 | 137,966,693.82 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 31,292,174.95 | 49,292,174.95 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -13,926,852.75 | - 15,078,963.38 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 1,000,000.00 | 19,500,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | - 1,000,000.00 | - 2,850,000.04 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 34,635,262.24 | 92,403,262.24 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | - 20,027,876.02 | - 33,502,829.79 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 8,921,996.08 | 30,174,496.08 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | - 8,878,922.53 | - 12,469,703.90 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 5,244,199.26 | 21,264,199.26 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | - 515,407.20 | - 10,765,941.60 |
| 393 | Биет бус хөрөнгө | 19,460,000.00 | 19,460,000.00 |
| 39301 | Программ хангамж | 636,389.00 | 636,389.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | - 636,389.00 | - 636,389.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 19,460,000.00 | 19,460,000.00 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | 257,964,907.79 | 245,024,090.03 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 257,964,907.79 | 245,024,090.03 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 257,964,907.79 | 245,024,090.03 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 54,993,149.59 | 54,993,149.59 |
| 51101 | Өмч: - төрийн | 54,993,149.59 | 54,993,149.59 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | 198,237,276.25 | 185,296,458.49 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 198,237,276.25 | 198,237,276.25 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | - 12,940,817.76 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 4,734,481.95 | 4,734,481.95 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | 257,964,907.79 | 245,024,090.03 |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

*2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* / төгрөгөөр /

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 583,131,515.92 | 540,308,801.34 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 90,084,045.92 | 61,188,863.45 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 85,874,045.92 | 61,188,863.45 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 85,874,045.92 | 00.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 85,874,045.92 | 00.00 |
| 1200018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого -Бараа материал | | 40,977,863.45 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого -Үндсэн хөрөнгө | | 20,211,000.00 |
| 122 | Тусламжийн орлого | 4,210,000.00 | 00.00 |
| 122001 | Хандив тусламж /дотоод/ | 4,210,000.00 | 00.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 116,124,030.00 | 465,935,529.88 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 376,923,440.00 | 00.00 |
| 131009 | Оны эхний үлдэгдлээс санхүүжих | 00.00 | 13,184,408.01 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | | |
| 1340 | Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих | 116,124,030.00 | 465,935,529.88 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 116,124,030.00 | 465,935,529.88 |
| 2 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 499,987,473.55 | 553,249,619.10 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 499,987,473.55 | 553,249,619.10 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 388,704,413.55 | 543,499,619.10 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 225,968,190.00 | 322,101,381.00 |
| 210101 | Үндсэн цалин | 225,968,190.00 | 167,574,985.00 |
| 210102 | Нэмэгдэл | 00.00 | 154,526,396.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 55,468,770.66 | 42,779,263.72 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 55,468,770.66 | 42,779,263.72 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 7,448,132.98 | 10,904,048.07 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,138,132.98 | 1,864,048.07 |
| 210302 | Түлш, халаалт | 6,310,000.00 | 9,040,000.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 29,702,028.91 | 31,636,476.51 |
| 210401 | Бичиг хэрэг | 12,811,190.00 | 7,755,980.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 2,075,000.00 | 2,759,400.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,989,059.60 | 1,939,721.51 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 330,000.00 | 600,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,196,660.00 | 5,284,160.00 |
| 210407 | Аж ахуйн материал худалдан авах зардал | 10,300,119.31 | 13,297,215.00 |
| 2105 | Нормативт зардал | 58,922,252.60 | 80,791,494.56 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 58,922,252.60 | 80,791,494.56 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 950,000.00 | 00.00 |
| 210604 | Урсгал засвар | 950,000.00 | 00.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 2,201,200.00 | 3,621,700.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 2,201,200.00 | 3,476,200.00 |
| 210703 | Зочин төлөөлөгч хүлээн авах | 00.00 | 145,500.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 6,228,388.00 | 2,005,023.60 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 6,076,720.00 | 1,949,295.60 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 49,500.00 | 00.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 80,168.00 | 33,728.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 22,000.00 | 22,000.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,815,450.40 | 49,660,231.64 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 00.00 | 19,341,851.43 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 1,815,450.40 | 30,318,380.21 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 111,283,060.00 | 9,750,000.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 111,283,060.00 | 9,750,000.00 |
| 213202 | Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж | 317,460.00 | 00.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 2,835,000.00 | 00.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 108,130,600.00 | 9,750,000.00 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2) | 83,144,042.37 | -12,940,817.76 |
| 225 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | 62,371,218.95 | 00.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 225005 | Үнэ төлбөргүй гарсан зардал | 62,371,218.95 | 00.00 |
| 4 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225) | -62,371,218.95 | 00.00 |
| 5 | НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4) | 20,772,823.42 | -12,940,817.76 |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

*2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* / төгрөгөөр /

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1) | 550,586,070.00 | 465,935,529.88 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 550,586,070.00 | 465,935,529.88 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 376,923,440.00 | 00.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 57,538,600.00 | 00.00 |
| 1340 | Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих | 116,124,030.00 | 465,935,529.88 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 116,124,030.00 | 465,935,529.88 |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2) | 562,432,733.24 | 455,220,659.33 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 562,432,733.24 | 455,220,659.33 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 453,504,673.24 | 445,470,659.33 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 224,703,111.00 | 319,886,333.00 |
| 210101 | Үндсэн цалин | 224,703,111.00 | 319,886,333.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 56,733,849.66 | 44,994,311.72 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 56,733,849.66 | 44,994,311.72 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 8,078,132.98 | 11,755,288.07 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,138,132.98 | 1,864,048.07 |
| 210302 | Түлш, халаалт | 6,910,000.00 | 9,770,000.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 30,000.00 | 121,240.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 79,111,399.60 | 25,856,356.51 |
| 210401 | Бичиг хэрэг | 13,568,690.00 | 9,941,810.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 2,995,000.00 | 2,809,400.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,989,059.60 | 1,939,721.51 |
| 210404 | Ном, хэвлэл | 68,200.00 | 00.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 330,000.00 | 600,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 7,658,350.00 | 4,312,325.00 |
| 210407 | Аж ахуйн материал худалдан авах зардал | 52,502,100.00 | 6,253,100.00 |
| 2105 | Нормативт зардал | 68,299,592.00 | 16,930,795.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 67,280,592.00 | 15,955,795.00 |
| 210502 | Хоол, хүнс | 194,000.00 | 00.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 825,000.00 | 975,000.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 2,225,000.00 | 00.00 |
| 210604 | Урсгал засвар | 2,225,000.00 | 00.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 2,201,200.00 | 3,621,700.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 2,201,200.00 | 3,476,200.00 |
| 210703 | Зочин төлөөлөгч хүлээн авах | 00.00 | 145,500.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 12,152,388.00 | 1,532,023.60 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 7,400,720.00 | 1,476,295.60 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 49,500.00 | 00.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 80,168.00 | 33,728.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 22,000.00 | 22,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 4,600,000.00 | 00.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 00.00 | 20,893,851.43 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 00.00 | 20,893,851.43 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 108,928,060.00 | 9,750,000.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 108,928,060.00 | 9,750,000.00 |
| 213202 | Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж | 317,460.00 | 00.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 3,756,700.00 | 00.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 104,853,900.00 | 9,750,000.00 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2) | -11,846,663.24 | 10,714,870.55 |
| 5 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5) | 00.00 | 4,120,000.00 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 00.00 | 4,120,000.00 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 00.00 | 4,120,000.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 00.00 | 4,120,000.00 |
| 6 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5) | 00.00 | -4,120,000.00 |
| 8 | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7) | -11,846,663.24 | 6,594,870.55 |
| 9 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 12,146,661.15 | 299,997.91 |
| 10 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 299,997.91 | 6,894,868.46 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

*2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* / төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | 2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 24,032,845.68 | 12,041,607.00 | -7,487,764.06 | 28,586,688.62 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 24,032,845.68 | 12,041,607.00 | -7,487,764.06 | 28,586,688.62 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | -3,235,463.04 | -3,235,463.04 |
| D01 | 2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 54,993,149.59 | 4,734,481.95 | 198,237,276.25 | 257,964,907.79 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 54,993,149.59 | 4,734,481.95 | 198,237,276.25 | 257,964,907.79 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | -12,940,817.76 | -12,940,817.76 |
| D09 | 2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 54,993,149.59 | 4,734,481.95 | 185,296,458.49 | 245,024,090.03 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

*2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* / төгрөгөөр /

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | | |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | | 455,840,659.33 | -455,840,659.33 | - |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | | 455,840,659.33 | -455,840,659.33 | - |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | | 446,090,659.33 | -446,090,659.33 | - |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | | 319,886,333.00 | -319,886,333.00 | - |
| 210101 | Үндсэн цалин | | 319,886,333.00 | -319,886,333.00 | - |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | | 44,994,311.72 | -44,994,311.72 | - |
| 210201 | Тэтгэврийн даатгал | | 44,994,311.72 | -44,994,311.72 | - |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | | 11,755,288.07 | -11,755,288.07 | - |
| 210301 | Гэрэл, цахилгаан | | 1,864,048.07 | -1,864,048.07 | - |
| 210302 | Түлш, халаалт | | 9,770,000.00 | -9,770,000.00 | - |
| 210303 | Цэвэр, бохир ус | | 121,240.00 | -121,240.00 | - |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | | 26,176,356.51 | -26,176,356.51 | - |
| 210401 | Бичиг хэрэг | | 9,941,810.00 | -9,941,810.00 | - |
| 210402 | Тээвэр, шатахуун | | 2,809,400.00 | -2,809,400.00 | - |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | | 1,939,721.51 | -1,939,721.51 | - |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | | 600,000.00 | -600,000.00 | - |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | | 4,312,325.00 | -4,312,325.00 | - |
| 210407 | Аж ахуйн материал худалдан авах зардал | | 6,573,100.00 | -6,573,100.00 | - |
| 2105 | Нормативт зардал | | 17,230,795.00 | -17,230,795.00 | - |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | | 16,255,795.00 | -16,255,795.00 | - |
| 210502 | Хоол, хүнс | | 0 | 0.00 | - |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | | 975,000.00 | -975,000.00 | - |
| 2107 | Томилолт, зочны зардал | | 3,621,700.00 | -3,621,700.00 | - |
| 210702 | Дотоод албан томилолт | | 3,476,200.00 | -3,476,200.00 | - |
| 210703 | Зочин төлөөлөгч хүлээн авах | | 145,500.00 | -145,500.00 | - |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | | 1,532,023.60 | -1,532,023.60 | - |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | | 1,476,295.60 | -1,476,295.60 | - |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | | 33,728.00 | -33,728.00 | - |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | | 22,000.00 | -22,000.00 | - |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | | 20893851.43 | -20,893,851.43 | - |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | | 20,893,851.43 | -20,893,851.43 | - |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | | 9750000 | -9,750,000.00 | - |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | | 9,750,000.00 | -9,750,000.00 | - |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | | 9,750,000.00 | -9,750,000.00 | - |
| | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 446,659,937.88 | 465,935,529.88 | -19,275,592.00 | - |
| 1340 | НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 446,659,937.88 | 465,935,529.88 | -19,275,592.00 | - |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 446,659,937.88 | 465,935,529.88 | -19,275,592.00 | - |
| 4 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 0 | 299,997.91 | -299,997.91 | - |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 0 | 6,894,868.46 | -6,894,868.46 | - |
| 62 | АЖИЛЛАГСДЫН ТОО | 16 | 16 | 0 | 100 |
| 620001 | Удирдах ажилтан | 1 | 1 | 0 | 100 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 11 | 11 | 0 | 100 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 4 | 4 | 0 | 100 |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Тус байгууллага нь Эрүүл мэндийн тухай хуулийн 16 дугаар зүйл “Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллагын чиг үүрэг” 16.1.Энэ хуулийн 15 дугаар зүйлд заасан байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хууль, болон нөхөрлөлийн тухай хуулийн 27 дугаар зүйл “Зарим гишүүд нь бүрэн хариуцлагатай нөхөрлөл”, 28 дугаар зүйл “Зарим гишүүд нь бүрэн хариуцлагатай нөхөрлөлийн онцлог”-д заасны дагуу зохион байгуулна.

Тайлант онд “Үйлчлэх хүрээний хүн амд нийгмийн эрүүл мэндийн болон эмнэлгийн анхан шатны тусламж үйлчилгээг жигд хүртээмжтэй, чанартай, ээлтэй, зохистой, аюулгүй хүргэж, тэдний эрүүл мэндийн байдлыг сайжруулж наслалтыг уртасгах.” гэсэн зорилгыг дэвшүүлэн ажиллажээ.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Ар мөнгөн чагнуур ЗГБХН нь ЭМЯ-ны харьяа гүйцэтгэлээр санхүүждэг нөхөрлөлийн хэлбэрээр зохион байгуулагдсан байгууллага бөгөөд үйл ажиллагаагаа Монгол улсад мөрдөгдөж байгаа хууль эрх зүйн хүрээнд явуулж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Эрүүл мэндийн даатгалын сангийн 2023 оны төсвийн хууль 2023.01.01-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө
- Төрийн хэмнэлтийн тухай хууль 2023.06.16-ны өдөр нэмэлт, 2023.07.07-ны өдөр нэмэлт өөрчлөлт орсон
- Төсвийн тухай хууль 2023.07.07-ны өдөр нэмэлт өөрчлөлт орсон
- Хөдөлмөрийн тухай хууль 2023.07.07-ны өдөр нэмэлт өөрчлөлт орсон
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль 2023.07.07-ны өдөр нэмэлт өөрчлөлт орсон
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль 2023.06.16-ны өдөр нэмэлт өөрчлөлт орсон

- Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай ЗГ-ын 2023.06.21-ны өдрийн 241 дүгээр тогтоол

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Ар-Мөнгөн чагнуур ЗГБХН нь 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус нөхөрлөл нь ЭМС-ын 2010 оны 04 дүгээр сарын 16 өдрийн 138 дугаар тушаалаар баталсан “Эрүүл мэндийн салбарт мөрдөх Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг мөрдөн ажилладаг ба тус бодлогын баримт бичиг нь холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцүүлэн өөрчлөлт оруулаагүй байна. Стандарт, хууль тогтоомжид нийцүүлэн өөрчлөлт оруулах шаардлагатай.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Ар мөнгөн чагнуур ЗГБХН -ийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 12,940.9 мянган төгрөгөөр буюу 5.0 хувиар буурсан байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт* *Мянган төгрөгөөр*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт | Хувь |
|---|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 | 4 |
| Мөнгөн хөрөнгө | 299.9 | 6,894.8 | 6,594.9 | 2,198.3 |
| Авлага | 0.0 | 13,184.4 | 13,184.4 | 0.0 |
| Бараа материал | 201,460.3 | 67,518.1 | (133,942.2) | -33.5 |
| Үндсэн хөрөнгө | 56,204.6 | 157,426.6 | 101,222.0 | 280.1 |
| **Нийт хөрөнгө** | **257,964.9** | **245,024.0** | **(12,940.9)** | **-5.0** |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 257,964.9 | 245,024.0 | (12,940.9) | -5.0 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | 257,964.9 | 245,024.0 | (12,940.9) | -5.0 |

Хүснэгтээс харахад, өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий дараах өөрчлөлтүүд гарсан байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл өмнөх оноос 6,594.8 мянган төгрөгөөр өссөн байна.

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 299.9 мянган төгрөг, тайлант оны эцэст 6,594.8 мянган төгрөгийн үлдэгдэлтэй 2,198.3 хувиар өссөн тайлант оны гүйцэтгэлээрх санхүүжилт нэмэгдэж орж ирсэнтэй холбоотой байна.

- Авлага 13,184.4 мянган төгрөгийн эцсийн үлдэгдэлтэй байгаа нь 2023 оны 12 дугаар сарын эмчлүүлэгчдийн 20 хувийн санхүүжилт дутуу орж ирсэнтэй холбоотой байна.

- Бараа материалын үлдэгдэл өмнөх оноос 133,942.2 мянган төгрөгөөр буурсан байна.

Бараа материалын данс нь 201,460.3 мянган төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдан авсан 50,170.1 мянга, үнэ төлбөргүй хүлээн авсан 40,977.7 мянга, нийт 91,148.0 мянган төгрөгөөр нэмэгдэж, тайлант онд зарцуулсан 117,880.7 мянган төгрөгөөр хасагдаж, эцсийн үлдэгдэл 67,518.1 мянган төгрөг байна. Өмнөх оноос буурсан шалтгаан нь аж ахуйн материалаас үндсэн хөрөнгө руу шилжүүлсэн байна.

- Үндсэн хөрөнгийн үлдэгдэл өмнөх оноос 101,222.0 мянган төгрөгөөр өссөн байна.

Үндсэн хөрөнгө данс нь 56,204.6 мянган төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант онд төсөв хөрөнгөөр худалдаж авсан 6,331.0 мянга, ЭМЯ-аас үнэ төлбөргүй хүлээн авсан 18,000.0 мянга, аж ахуйн материалаас шилжүүлэн бүртгэсэн 107,209.5 мянга нийт 131,540.3 мянган төгрөгөөр нэмэгдэж, 30,318.3 мянган төгрөгийн элэгдэл байгуулагдаж, үндсэн хөрөнгийн эцсийн үлдэгдэл 157,426.6 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

- Цэвэр хөрөнгө өмчийн дүн буурсан нь тайлант үеийн үр дүн, алдагдлыг -12,940.8 мянган төгрөгөөр хүлээн зөвшөөрч бүртгэсэнтэй холбоотой байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг эрүүл мэндийн даатгалаас 404,552.5 мянга, нийт зарлагыг 404,552.5 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас эрүүл мэндийн даатгалын санхүүжилт 42,107.4 мянган төгрөг, тус өсгөж, эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүжилтийг 446,659.9 мянган төгрөгөөр баталсан байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсөвт өөрчлөлт ороогүй. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн санхүүжүүлэхээр 446,659.9 мянган төгрөгийг эрүүл мэндийн даатгалын сангийн орлогоос бүрдүүлсэн байна.

Тайлант онд буцаан төсөвт төвлөрүүлэх шилжүүлэг байхгүй.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 465,935.5 мянган төгрөг буюу 104.3 хувьтай, төрийн сангийн дансанд 6,894.8 мянган төгрөгийг үлдэгдэлтэй байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл* мянган төгрөгөөр

| № | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| 1 | 71602-Эмнэлгийн тусламж үйлчилгээ | 446,659.9 | 465,935.5 | -19,275.6 | 104.3 |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй. Тайлант жилд нэмэлт санхүүжилт аваагүй байна.

### 3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Ар-Мөнгөн чагнуур ЗГБХН-ийн 2023 онд хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр байхгүй.

### 3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант жилд 4,120.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг шууд гэрээгээр худалдан авсан байна.

# 4. АУДИТЫН ТАЙЛАН

## 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Ар мөнгөн чагнуур ЗГБХН-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг “Бизкон аудит” ХХК Архангай аймаг дахь салбарын аудитор Д.Должинсүрэн, Ц.Отгон-Оюун, Б.Бөхболд, Л.Энхцэцэг нар гүйцэтгэж, арга зүйгээр хангах, удирдан зохион байгуулж үе шатны хяналтыг салбарын захирал Ч.Анхбаяр нар гүйцэтгэлээ. Архангай аймаг дахь Төрийн аудитын газраас арга зүйгээр хангах, үе шатны хяналтыг аудитын менежер Д.Нэргүйбаатар, удирдан зохион байгуулж үе шатны хяналтыг Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа нар тус тус хэрэгжүүлсэн.

Ар мөнгөн чагнуур ЗГБХН-ийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Бизкон аудит” ХХК Архангай аймаг дахь салбарт 2024 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 01 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

## 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-д заасны дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2023 оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны тодотгон батлагдсан төсөв 446,659.9 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 4,466.6 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 3,126.6 мянган төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг хянаж үзээд шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

## 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Тайлант онд Монгол Улсын Их Хурлаас Төрийн хэмнэлтийн тухай хуулийг 2022 оны 04 дүгээр сарын 29-нд баталж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах эрх бүхий байгууллага нь төрийн аудитын байгууллага байна гэж заасан. Үүний дагуу “Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих бодлого, чиглэл”-ийг МУЕА-ын 2022 оны 07 дугаар сарын 19-ны өдрийн А/59 дүгээр тушаалаар, “Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих, чиглэлийг хэрэгжүүлэх заавар”-ыг МУЕА-ын 2022 оны 11 дүгээр сарын 25-ны А/89 дүгээр тушаалаар баталж, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хянаж ажилласан болно.

Тус байгууллага нь нийт 6,894.8 мянган төгрөгийн хэмнэлтийг бий болгож төрийн сангийн харилцах дансанд үлдээсэн байна.

Тайлант онд Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотойгоор ҮАГ-аас 4 төрлийн судалгаа авахаар ирүүлсэн бөгөөд тус байгууллагад хамаарах 1 судалгаа буюу худалдан авах ажиллагааны судалгааг авч хяналаа.

**Ерөнхий чиглэлийн судалгааны талаар:**

- Тус байгууллагын албан хаагчдад орон нутгийн төсвөөс дэмжлэг, урамшуулал, хөнгөлөлт олгоогүй байна.
- Тус байгууллагын эзэмшилд Пургон авто машин 2ш, шатахууны зардал 2,809.4 мянга, засвар үйлчилгээ болон бусад зардал 1,020.0 мянга нийт 3,829.4 мянган төгрөгийн автомашин ашиглалттай холбоотой зардал гарсан байна.

Тус ЭМТ-ийн санхүүгийн тайланд албан газрын зориулалттай дараах газрууд бүртгэлтэй байна. Үүнд:

- 0000100051 гэрчилгээний дугаартай, 6513010314 нэгж талбайн дугаар 920 м.квт талбайтай, 0.0 мянган төгрөг
- 0000099352 гэрчилгээний дугаартай, 6513010907 нэгж талбайн дугаар 1026 м.квт талбайтай, нийт 19,460.0 мянган төгрөг

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Ар-Мөнгөн чагнуур ЗГБХН нь тайлант хугацаанд шилэн дансанд оруулбал зохих мэдээллийн сонголтыг хийлгээгүй, шилэн дансанд мэдээлэл байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-т "Доор дурдсан байгууллага, түүний эд хөрөнгө захиран зарцуулах эрх бүхий албан тушаалтан энэ хуулийн үйлчлэлд хамаарна", 3.1.5 “Төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч.", 5.1.Байгууллага нь шилэн дансны мэдээллийг өөрийн цахим хуудсаар хүргэх бөгөөд цахим хуудас нь дараах шаардлагыг хангасан байна" 5.1.1-т "Шилэн дансныбие даасан цэстэй байх" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь:Зөрчлийг арилгуулах, таслан зогсоох албан шаардлага хүргүүлэх

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

#### 4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар тус байгууллагын 2023 оны санхүүгийн тайлангийн аудитын урьдчилсан болон төлөвлөх шатны ажлыг 2023.12.27-2023.12.30-ны хооронд хийж гүйцэтгэсэн.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

*Хүснэгт 4 Төлбөрийн акт,* албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Акт | 2 | 15,587.0 | 2 | 15,587.0 | 100 |
| Албан шаардлага | 6 | 199,172.7 | 6 | 199 | 100 |
| Зөвлөмж | 3 | 0.0 | 3 | 0.0 | 100 |
| **Нийт дүн** | **11** | **214,759.7** | **11** | **214,759.7** | **100** |

Тус байгууллага нь өмнөх оны биелэлтийг 2023 оны 03 сарын 31-ны өдрийн 21, тоот албан бичгээр Төрийн аудитын газарт ирүүлж, www.fas.audit.mn цахим системээр үнэлүүлсэн байна.

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар худалдан авалт, цалин хөлс нэмэгдэл урамшуулал, үндсэн хөрөнгө, бараа материалын бүртгэл анхааран авч үзнэ.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар алдаа[1] илрээгүй. Харин залруулагдаагүй нийт 16,230.9 мянган төгрөгийн зөрчил[2] илэрсэнд зөрчлийг арилгах 1 төлбөрийн акт, 1 албан шаардлага хүргүүллээ.

Аудитаар залруулагдаагүй материаллаг алдааны зөрчил нь 16,230.9 мянган төгрөг бөгөөд тогтоосон материаллаг байдлын дүн 3,126.6 мянган төгрөгөөс их байгаа тул **Хязгаарлалттай** дүгнэлт өглөө.

### 5.1 Төлбөрийн акт

5.1.1 2023 оны санхүүгийн тайлангаар 12,940.8 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байхад нийт ажилтнуудад 3,290.1 мянган төгрөгийн 13 дахь сарын цалинг олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Байгууллагын дотоод журмын 1.9.12 дахь заалт "Байгууллага санхүүгийн үр ашигтай ажилласан тохиолдолд 13 дахь сарын цалинг нийгмийн даатгал, ХХОАТ-ыг суутгаж олгож болно" гэсэн заалтыг зөрчсөн байна.

*Шийдвэрлэсэн нь*: Төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоолоо.

### 5.2 Албан шаардлага

2023 оны санхүүгийн тайлангаар 12,940.8 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байхад нийт ажилтнуудад 12,940.8 мянган төгрөгийн 13 дахь сарын цалинг олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Байгууллагын дотоод журмын 1.9.12 дахь заалт "Байгууллага санхүүгийн үр ашигтай ажилласан тохиолдолд 13 дахь сарын цалинг нийгмийн даатгал, ХХОАТ-ыг суутгаж олгож болно" гэсэн заалтыг зөрчсөн байна.

*Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.*

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Алдагдалтай ажилласан байхад урамшуулалт цалин олгосон | 1 | 16,230.9 | 1 | 3,290.1 | 1 | 12,940.8 | | | | | | |
| **Дүн** | **1** | **16230.9** | 1 | 3,290.1 | **1** | 12,940.8 | | | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| Мэдээлэл дутуу байршуулсан | 1 | 0 | | | 1 | 0 | | |

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

[2] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| дүн | 1 | 0 | | | 1 | 0 | | |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| | | | | | | | | |
| дүн | | | | | | | | |
| **Нийт дүн** | **1** | **0** | | | **1** | **0** | | |